



**ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2022 оны 02 сарын 10 өдөр

Дугаар 07/09

Эрдэнэт


“Хурлын хорооны үйл ажиллагааны
журам” батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 45 дугаар зүйлийн 45.5 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит VII хуралдаанаас **ТОГТООХ** нь:

1. “Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хорооны үйл ажиллагааны журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Журмыг мөрдөж ажиллахыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хороодын дарга, бүрэлдэхүүнд даалгасугай.

ДАРГА



Д. МӨНХБАТ

079130025

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022
оны 02 дугаар сарын 10-ны өдрийн Ээлжит VII
хуралдааны 07 дүгээр тогтоолын хавсралт

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

Нэг. Журмын зорилго

1.1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал /цаашид “Хурал” гэх/-ын хорооны үйл ажиллагааг энэ журмаар зохицуулна.

1.2.Хороо нь Хурлын тасралтгүй, байнгын үйл ажиллагааг хангаж, Хурлын хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэж, санал, дүгнэлт гаргах, Хурлын тогтоол, шийдвэрийн биелэлтийг хянан шалгах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Хоёр. Хурлын хороо байгуулах, бүрэлдэхүүн, даргыг сонгох

2.1.Хурлын хуралдаанаар хороог энэхүү журмын 2.3 дахь хэсэг болон орон нутгийн онцлогийг баримтлан байгуулна.

2.2.Ажлын шаардлагыг харгалзан нам, эвслийн бүлэг, бүлэгт харьяалагдаагүй төлөөлөгчдөөс урьдчилан санал авсны дагуу Хурлын бүрэн эрхийн хугацаанд ажиллах хороог Хурлын даргаас санал оруулан хэлэлцүүлж батлуулна.

2.3.Хурлын даргаас оруулсан саналыг хуралдаанаар хэлэлцэн олонхын саналаар хорооны бүрэлдэхүүнийг батална.

2.4.Хурлын хороог байгуулж, бүрэлдэхүүнийг баталсны дараа хурал түр завсарлаж, хороо бүр тусгайлан хуралдаж, тухайн хорооны даргад нэр дэвшүүлэх асуудлыг хэлэлцэх бөгөөд хуралдааныг хорооны хамгийн ахмад төлөөлөгч нь удирдан хуралдуулж, бүрэлдэхүүнд нь орсон төлөөлөгчдийн дотроос олонхын саналаар хорооны даргад нэр дэвшүүлнэ.

2.5.Хурлын хорооны саналыг хорооноос даалгасан аль нэг төлөөлөгч танилцуулах бөгөөд хорооны саналыг үндэслэн хуралдаанаас Хурлын хорооны даргыг сонгосон тухай тогтоол гаргана.

Гурав. Хурлын хороодын бүтэц

3.1.Хурал нь өөрийн нутаг дэвсгэр, хүн амын тоо газар зүйн байршил, аж ахуй нийгэм, эдийн засгийн хөгжлийн онцлог, төлөөлөгчдийн тоог харгалзан хороог 5-7 гишүүнтэйгээр сонгож байгуулна. Хорооны нэр, бүтэц бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах асуудлыг аймгийн ИТХ-ын хуралдаанаар шийдвэрлэнэ.

3.2.Хурал нь дараах нэр бүхий хороог байгуулж ажиллуулна:

3.3.1.Эрх зүй, нутгийн удирдлагын хөгжлийн хороо;

3.3.2.Нийгмийн хөгжлийн хороо;

3.3.3.Эдийн засаг, үйлдвэрлэлийн хөгжлийн хороо;

3.3.4.Төсөв, санхүүгийн хөгжлийн хороо;

3.3.5.Байгаль орчин, хөдөө аж ахуйн хөгжлийн хороо;

3.3.6.Дэд бүтэц, хот байгуулалт, гэр хорооллын хөгжлийн хороо;

3.3.7.Цахим бодлогын хөгжлийн хороо;

3.3.8.Ёс зүйн хороо.

3.3.Орон нутгийн хөгжлийн бодлого, чиглэл, цаг үеийн шаардлага, гаргасан шийдвэрийн хэрэгжилт, иргэдийн эрэлт хүсэлтийг үндэслэн ажлын хэсэг байгуулан ажиллуулж болно.

3.4.Хорооны дарга, бүрэлдэхүүнд Хурлын хуралдаанаар жил тутамд 50 хувь хүртэл өөрчлөлт оруулж болно.

3.5.Ёс зүйн хороо нь Хуралд хамгийн олон удаа сонгогдсон 5 төлөөлөгчөөс бүрдэнэ.

3.6.Хорооны хурлыг хорооны дарга удирдаж, гишүүддээ ажил үүрэг хуваарилж, гишүүдийн ажлыг дүгнэж, хуралдаанд ажлаа тайлагнаж, санал, дүгнэлт гаргах, тэмдэглэл, албан бичигт гарын үсэг зурна.

Дөрөв. Хороодын үйл ажиллагааны чиглэл

4.1.Хороод нь Хурлын хуралдаанаар хэлэлцэх асуудлыг бэлтгэх, судлах, санал дүгнэлт гаргах асуудлаар гишүүдийг оролцуулж, хуваарь гарган ажиллуулж, дүн мэдээллийг хорооны хурлаар хэлэлцэж, санал дүгнэлтээ нэгтгэнэ.

4.2.Байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, холбогдох иргэдийн Төлөөлөгчдийн /Нийтийн/ Хурал, иргэд сонгогчид, судлаачдын санал бодлыг судалж, санал дүгнэлтийг боловсруулна.

4.3.Хурлын хуралдаанаар хэлэлцэх асуудлаар болон гаргасан шийдвэрийн талаар иргэд, олон нийтэд мэдээлэл өгөх, шаардлагатай тохиолдолд ярилцлага, хэлэлцүүлэг хийх, нээлттэй сонсгол хийх, өдөрлөг, уулзалт зэрэг олон нийтэд зориулсан арга хэмжээг зохион байгуулж ажиллана.

4.4.Хорооны гишүүдийг эрхэлсэн ажил, мэргэжил, туршлага, хүсэл сонирхлыг харгалзан хоёроос доошгүй хороонд харъяалуулан ажиллуулна. (Энэхүү заалт нь Ёс зүйн хороонд үл хамаарна).

4.5.Хурлын хуралдаанаас гаргасан шийдвэр болон төлөөлөгчдөөс гаргасан санал, дүгнэлтийн мөрөөр хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт гарган, шаардагдах тогтоол, журамд нэмэлт, өөрчлөлт оруулах саналын хамт Хурлын зөвлөлийн болон Хурлын хуралдаанд тухай бүр хэлэлцүүлж ажиллана.

4.6.Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн болон тухайн жилийн эдийн засаг, нийгмийн зорилтын биелэлт, төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэл, хандивын хөрөнгийн зарцуулалтад, хяналт шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт гаргаж танилцуулна.

4.7.Хороо нь хуралдаанаар хэлэлцэх асуудал болон гаргасан шийдвэр, тавьсан зорилтын биелэлтийг дүгнэхдээ судалгаа, мэдээллийг харьцуулж, жиших, учир шалтгааныг судлан үзэж, холбогдох хууль тогтоомжтой нийцүүлж санал, дүгнэлт гаргана.

Тав. Хорооны үйл ажиллагааны зохион байгуулалт

5.1.Хороо нь ажлаа жилээр төлөвлөн тайлагнаж, шаардлагатай тохиолдолд хагас жил тутам тайлангаа Хурлын хуралдаанаар хэлэлцүүлнэ.

5.2.Хорооны үйл ажиллагааны зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь хорооны хуралдаан байна.

5.3.Хороо нь Хурлын хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэх, санал дүгнэлт гаргахаар хуралдана. Хурлын тогтоол, шийдвэрийн биелэлтийг хянан шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлэхдээ Хурлын даргаар батлуулсан удирдамж, хөтөлбөрийг удирдлага болгоно.

5.4.Хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлаар бэлтгэсэн бичиг баримтаа гишүүддээ 1 хоногийн өмнө хүргүүлсэн байна. Хорооны хуралдааныг Хорооны дарга удирдана. Хорооны даргын эзгүйд хуралдаанд оролцож буй гишүүдийн олонхын саналаар хурал даргалах гишүүнийг сонгоно.

5.5.Хорооны хуралдаанд гишүүн бүр оролцох бөгөөд нийт гишүүдийн гуравны хоёроос доошгүй хувийн бүрэлдэхүүнтэйгээр хуралдаж асуудлыг ердийн олонхоор шийднэ. Хорооны ажилд гишүүн бүр идэвх санаачилгатай, ажил хэрэгч байдлаар оролцох үүрэгтэй.

5.6.Хорооны хурлын тэмдэглэлийг тухай бүр хөтлөх бөгөөд санал, дүгнэлт гаргах, асуулга тавих, хуралдаанд болон хорооны хуралдаанд оруулсан асуудал, албан тушаалтанд өгсөн албан бичиг, зөвлөмж, түүний хариу авсан судалгаа мэдээлэл, өргөдөл хүсэлт, түүний дагуу хийсэн ажил зэрэг нь хорооны ажлын үндсэн бичиг баримт байна.

5.7.Хорооноос аймгийн Засаг дарга, түүний харьяа байгууллага, аж ахуйн нэгжид өгөх албан бичиг, саналаа Хурлын дарга, нарийн бичгийн дарга нарт танилцуулж хэвлэмэл хуудас, тамгыг хэрэглэнэ.

5.8.Хороо нь хариуцсан ажлынхаа чиглэлээр эрдэмтэн судлаачид, мэргэжилтнүүд, төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг байгуулах саналаа Хурлын хуралдаанд шийдвэрлүүлнэ.

5.9.Хороо нь хэлэлцсэн асуудлаар санал дүгнэлт гаргана.

5.10.Хороо нь хийсэн ажил, гишүүдийн оролцооны байдлаа шаардлагатай тохиолдолд хагас жил тутам иргэд, олон нийтэд танилцуулж байна.

5.11.Хороо нь бичиг баримт, судалгаа, дүгнэлт, тайлангаа жилээр нэгтгэн Хурлын ажлын албаны хариуцсан ажилтанд хүлээлгэн өгнө.

Зургаа. Хурлын хорооны даргын чиг үүрэг

6.1.Хорооны дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

6.1.1Хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулна;

6.1.2.Хорооны хуралдааны бэлтгэлийг хангаж, зохион байгуулж хуралдуулна;

6.1.3.Хорооны хуралдааныг удирдана;

6.1.4.Хорооны нэрийн өмнөөс бусад байгууллагатай харилцана;

6.1.5.Хорооны ажлыг Хурлын өмнө хариуцан тайлагнана.

Долоо. Хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, өөрчлөх, татан буулгах

7.1.Хурлын дарга, Хурлын Зөвлөлөөс хорооны үйл ажиллагааны зардлын төсвийг жил бүрийн төсөвт тусгаж санхүүжүүлэх ба бусад шаардлагатай дэмжлэг

туслалцааг үзүүлнэ. Хорооны санхүүжилтийн тайланг хууль журмын дагуу гаргах үүргийг хорооны дарга хүлээнэ.

7.2.Хурлын ажлын албаны ажилтнуудад хороог хариуцуулан хурлын бэлтгэл хангах, гишүүдэд зар мэдээ хүргэх, бичиг хэрэг, архив бүрдүүлэх, шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах ажлыг хариуцуулан туслуулна.

7.3.Хорооны ажлын тайланг Хурлын хуралдаанаар бүтэн жилээр хэлэлцэж үнэлгээ дүгнэлт өгнө.

7.4.Хороо, түүний гишүүдийн ажлын сайн туршлага, санаачилгыг төв, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийтэд сурталчлах ажлыг Хурлын ажлын алба хариуцаж ажиллана.

7.5.Хороог ажлын шаардлагаар нийлүүлэх, нэгтгэх, хуваах замаар өөрчлөн байгуулах; хорооны чиг үүрэг өөрчлөгдсөн, эсвэл хорооны чиг үүрэг бүхэлдээ өөр хороонд шилжсэн тохиолдолд тухайн хороог татан буулгах шийдвэрийг Хурлын хуралдаанаар хэлэлцэж тогтоол батална.

Найм. Бусад

8.1.Хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Хурлын зөвлөлийн болон Хурлын хуралдаанаар хэлэлцүүлнэ.

8.2.Энэ журамд шаардлагатай гэж үзвэл Хурлын хуралдаанаар нэмэлт, өөрчлөлт оруулж болно.